



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №1

2019 оны 12 дугаар сарын 30-наас, 01 дүгээр сарын 03

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй байна.

1.1 Мэрэгч амьтны дуудлага

2019 оны 01 дүгээр сарын 02-нд Нийслэлийн СХД-ийн “Эмээлт” АТШН товчооноос ирүүлсэн мэрэгч амьтны (тарвага) 1 удаагийн дуудлагад үйлчилж, эрсдэлийг тодорхойлохоор лабораторийн шинжилгээ хийж байна.

ХОЁР. ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Өвөрхангай аймгийн Бүрд сумын Донгит багийн “Цагаан Толгой” гэдэг газар малчин “Э”-ын 1 үхэр 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул сорьц авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын захирамжаар 12 дугаар сарын 29-ны өдрийн А/122 дугаар захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон.

Нийт 1 өрхийн 60 үхэр, 4 нохойг вакцинжуулж, ариутгал халдваргүйтгэл хийжээ.

Эх сурвалж: ОБЕГ

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:



Өвөрхангай аймгийн Тарагт сумын Туяа багийн “Хашаат” гэдэг газар малчин “Ж”-ын 1 үхэр 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул сорьц авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын захирамжаар 12 дугаар сарын 31-ний өдрийн А/161 дугаар захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон. Нийт 387 мал, амьтныг вакцинжуулсан байна.

Эх сурвалж: ОБЕГ

Олон улсад:

Эбола вируст халдвар:

2019 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй 3351 тохиолдол бүртгэгдсэнээс 2217(66%) нь нас барсан байна. Нийт тохиолдлын 1886(56%) нь эмэгтэйчүүд, 941(28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзлэж байна. ЭМБ-ын ажилчид 169(5%) нь халдвар авсан.



Эх сурвалж: ДЭМБ

Шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа өвчин:


БНХАУ-ын Эрүүл мэндийн газраас Хубэй мужийн Ухон хотын далайн бүтээгдэхүүн зардаг захад шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа өвчний 27 тохиолдлыг мэдээлсэн. Тандалт судалгаагаар эдгээр тохиолдлуудад ихэвчлэн халуурах, зарим тохиолдолд амьсгал давчдах шинж тэмдэг илэрсэн байна. Одоогоор 7 тохиолдлын биеийн байдал хүн байна. Бүгд тусгаарлагдсан. Одоогоор хүнээс хүнд дамжсан тохиолдол байхгүй. Тандалт судалгаа үргэлжилж байна.



Эх сурвалж: outbreaknewstoday.com

Африкийн гахайн мялзан өвчин:

Румын улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 12 дугаар сарын 30-нд Супур хотын Сату Маре тосгоны цэцэрлэгт хүрээлэнд африкийн гахайн мялзан өвчнөөр 1 зэрлэг гахай өвчилж үхсэн байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

ЗӨСҮТ, Шуурхай удирдлагын нэгж

nczd.eop@gmail.com

eop@nczd.gov.mn